

**ЗАВХАН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2017 ОНЫ 12 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

1.1.Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлыг 3 удаа хийж “Сайн оюутан” дэд хөтөлбөр батлах тухай, Аймгийн “Боловсрол соёл урлагийн салбарыг хөгжүүлэх” дэд хөтөлбөр батлах тухай, “Зөв монгол хүүхэд” аймгийн дэд хөтөлбөрийн тайлан мэдээлэл, Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, Аймгийн эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай, Аймгийн 2018 оны төсвийн төсөл 2018 онд төсвийн орлого нэмэгдүүлж зарлага хямдруулах санал, “Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн” дэд хөтөлбөр батлах тухай, Баг шинээр байгуулах тухай, Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, Аймгийн 2017 оны төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэл, 2018 оны төсвийн төсөл, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс 2017 онд хийсэн ажлын тайлан, Аймгийн ИТХ, Тэргүүлэгчдийн шийдвэрийн хэрэгжилт, Аймгийн ойн менежментийн төлөвлөгөө, 2018 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаар батлах тухай зэрэг 15 тогтоол 10 тэмдэглэл гаргаж биелэлтийг хангуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж ажиллаж байна.

2017 оны 12 дугаар сарын 04-ны өдөр аймгийн ИТХ-ын 5 дугаар хуралдааныг хуралдуулж хурлаар 8 тогтоол гарсныг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн. Мөн хуралдааны материалыг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

Бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын цахим хуудас khural.mn сайтын дэд цахим хуудсыг хөтөлж хөгжүүлэх улсын уралдаанд оролцож II байрт шалгарлаа. Мөн сургалт зохион байгуулж тогтмол зөвлөн тусалж ажилласнаар Улиастай, Их-Уул сум I, II байрт шалгарч бусад сум амжилттай оролцсон.

Аймгийн хэмжээнд Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсан өдөрт зориулсан Улсын Их Хурлын дарга М.Энхболдын ивээл дор сумдад 2017 оны 11 дүгээр сарын 18-19-ний өдрүүдэд Шатар сонирхогчдын 2017 оны сумын аварга шалгаруулах буюу анхан шатны тэмцээний зааврыг 96 ширхэг талархлын хамтаар

хүргүүлж зохион байгуулж ажиллаа. Энэ удаагийн шатар сонирхогчдын анхан шатны тэмцээнд 24 сум амжилттай зохион байгуулж эрэгтэй 320 эмэгтэй 62 шатарчин оролцож оюун ухаанаа уралдуулж, шатар сонирхогчдын сумын аваргуудыг тодруулсан байна. Мэдээ тайланг холбогдох газарт нэгтгэж хүргүүлэсэн.

Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс ирүүлсэн хүснэгтийн дагуу Завхан аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2017 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах ажлын албанд хүргүүлж ажиллаа.

Аймгийн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссоос “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай” хууль болон түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтийн тухай хуулийг сурталчлах, хэрэгжүүлэх, хяналт тавих ажлыг зохион байгуулж, нөхөн олговрын материалыг бүрдүүлэхэд иргэдэд хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх талаар байнга анхаарч ажиллахын зэрэгцээ, цагаатгалын асуудлаар иргэдийг цаг хугацаа харгалзахгүйгээр хүлээн авч, нөхөн олговрын материал бүрдүүлэхэд нь хууль эрх зүйн болон арга зүйн дэмжлэг туслалцааг үзүүлэн ажиллаж байна.

1.2. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:

Аймгийн ИТХ-ын 5-р хуралдаанаар аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэлийн биелэлт, Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг хэлэлцүүлж, үндсэн чиглэлийн хэрэгжилт 97,2 хувийн биелэлттэй буюу маш сайн хэрэгжсэн, үйл ажиллагааны хөтөлбөрийн нэг жилийн хугацаанд хийсэн ажлыг 93.7 хувийн хэрэгжилттэй буюу хангалттай сайн гэсэн үнэлгээ өгч дүгнэлээ.

2018 оны үндсэн чиглэлийн төслийг “Ард иргэдээ сонсох аян”-ы хүрээнд иргэд, байгууллага аж ахуйн нэгжүүдээс авсан саналуудыг үндэслэн ажлын хэсгийн 8 удаагийн хурал, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал, ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар тус тус хэлэлцүүлэн боловсруулсан.

2018 онд бүх сумд тохижилт, соёлжилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх “Миний гоё сум” хөтөлбөр хэрэгжүүлэх, Хүүхдийн цэцэлэгүүдийг камержуулах, Залуу малчдын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх “Гэр өргөө”-г сум бүрийн сургуулийн дотуур байранд байгуулна. Мөн 2018 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн онцлог нь “Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагын жил” болгож энэ хүрээнд төрийн албан хаагчдыг чадавхжуулах

зорилгоор удирдах ажилтны зөвлөгөөн, төрийн албан хаагчдын бүсчилсэн сургалтуудыг зохион байгуулах, төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл орчныг сайжруулах, засаг захиргааны анхан шатны нэгж болох багийн Засаг дарга нарыг унаажуулах, компьютержуулах, бүх төрийн байгууллагуудад е-оффис программыг нэвтрүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд ил тод, нээлттэй байж, иргэдээрээ ажлаа үнэлүүлэх, иргэдийн саналыг авч ажилдаа тусгах, төрийн цогц үйлчилгээг багт хүргэх, иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлж “Таны туслагч” номыг иргэн бүрт хүргэх зэрэг олон онцлог арга хэмжээнүүдийг тусган хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Төрийн албаны зөвлөлийн Завхан аймаг дахь салбар зөвлөлөөс 2017 оны 12 сарын 03 буюу өвлийн эхэн сарын билэгт сайн өдөр Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын ажиллагааг Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигаар баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ын дагуу зохион байгууллаа. Энэхүү ёслолын ажиллагаанд Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалт болон төрийн жинхэнэ албанд анх орох иргэний мэргэшлийн шалгалтад тэнцэн төрийн захиргааны нэр хүндтэй, хариуцлагатай албан тушаалд шинээр томилогдон ажиллаж байгаа 15 байгууллага, 11 сумын 57 төрийн албан хаагч тангараг өргөлөө. Тангараг өргөх ёслолын ажиллагаанд аймгийн Засаг дарга, ИТХ-ын дарга, Орлогч дарга нар оролцож, баяр хүргэлээ.



Энэ удаагийн тангараг өргөх ёслолын ажиллагаа нь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалтанд тэнцэж, тухайн албан тушаалдаа нэр дэвшиж томилогдсон сумдын Засаг даргын Тамгын газрын болон ИТХ-ын удирдах ажилтнуудыг оролцуулж, зохион байгуулснаараа онцлогтой байлаа.



Монгол Улсын Засгийн газрын “Сахилга хариуцлага, дэг журмыг сайжруулах” 2017 оны 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулан Төрийн болон Төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудад хүргүүлсэн. Албан даалгаврын хэрэгжилтийн тайлан мэдээг нэгтгэн ЗГХЭГ-т холбогдох мэргэжилтэнд нь 2017 оны 12 сарын 11 өдөр хүргүүллээ.

2017 оны 12 сарын 25-ны өдөр Засаг даргын Зөвлөлийн ээлжит хурал хуралдсан. Зөвлөлийн хуралдаанаар:

- Засгийн газрын тогтоол шийдвэрийн 2017 оны хэрэгжилт
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2017 оны хэрэгжилт
- Улсын сайн малчинд тодорхойлогдсон малчдыг шалгаруулах
- Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн хагас жилийн тайлан зэрэг асуудлыг хэлэлцсэн.

Мөн 2017 оны 12 сарын 26-ны өдөр Төрийн албаны зөвлөлийн Завхан аймаг дахь салбар зөвлөлийн хуралдаан болсон. Хуралдаанаар:

- Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын дагуу зохион байгуулсан сонгон шалгаруулалтын дүнг хэлэлцүүлж дүгнэлт хүргүүлэх тухай

- Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60-р тогтоолоор батлагдсан “Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын дагуу зохион байгуулсан сонгон шалгаруулалтын дүнг хэлэлцэх
- “Төрийн албаны тэргүүн” цол тэмдгээр шагнуулах төрийн албан хаагчдыг уламжлах тухай
- 2017 онд зохион байгуулсан удирдах ажилтны сонгон шалгаруулалтын шалгалтын хураамжийн зарцуулалтын тайлан
- Цагаанхайрхан сумын ЗДТГ-ын Байгаль орчны улсын хяналтын байцаагчаар ажиллаж байсан Н.Өлзий-Ачийн өргөдөл, гомдлыг шалгасан ажлын хэсгийн дүгнэлтийг хэлэлцэх
- Эрүүл мэндийн газрын Хүүхдийн тусламж, үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Ганчимэгийн өргөдөл, гомдлыг шалгасан ажлын хэсгийн дүгнэлтийг хэлэлцэх
- Сантмаргаз сумын бүрэн дунд сургуулийн багш Р.Анхтуяагийн өргөдөл, гомдлыг шалгасан ажлын хэсгийн дүгнэлтийг хэлэлцэх зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлангийн программ шинэчлэгдсэнтэй холбогдуулж төрийн албан хаагчдын анкетыг шинэчлэн оруулж байна.

Монгол улсын цол, Төрийн дээд одон медалиар шагнагдахаар тодорхойлогдсон худалдаа, үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, эдийн засаг, хөдөө аж ахуйн салбарт олон жил үр бүтээл, идэвх санаачлагатай ажилласан 26 иргэний материалыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 12 сарын 13-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, тогтоол гаргуулан Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжилсан.

Үүнд: Алтан гадас одон-14, Хөдөлмөрийн хүндэт медаль-12

2017 оны 12 сарын 22-ны өдөр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар төрийн дээд одон медалиар шагнагдахаар тодорхойлогдсон 7 иргэний материалыг хэлэлцүүлэн, Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжлахаар бэлтгэж байна.

2017 оны 01-р сарын 13-ны өдрөөс 01-р сарын 18-ны өдрийн хооронд Аймгийн Засаг дарга Д.Батсайхан тэргүүтэй төлөөлөгчид БНХАУ-ын Бээжин, Шиан хотуудын аялал, жуулчлалын салбарын хөгжлийн туршлага судлах мөн "Нүүдэлчдийн соёлын наадам"-ыг сурталчлан гадаадын жуулчдыг оролцуулах

зорилгоор аялал жуулчлалын компаниудын төлөөлөлтэй санал солилцох уулзалт хийлээ.

Аймгийн Засаг дарга болон Засаг даргын Тамгын газарт нийт 296 албан бичиг ирсэн. Одоогийн байдлаар 9-н албан бичиг хугацаа нь болоогүй хүлээгдэж байна.

Аймгийн Засаг дарга болон Засаг даргын Тамгын газраас нийт 125 албан бичигт дугаар олгосон байна.

Хот болон аймаг сумын нийт 88 албан бичгийг Шуудан холбоогоор дамжуулан холбогдох газарт нь хүргүүлсэн байна. Байгууллагуудад эх хувиараа хүргэгдэх 58 албан бичгийг өөрийн биеэр хүргэж ажилласан.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:

2.1. Төсөв: Аймгийн хэмжээгээр 2017 оны 12 сарын 01-ний байдлаар төсвийн зарлага 56 тэрбум 227,2 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 53 тэрбум 14,8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд татварын орлогоор орон нутгийн төсөвт 5 тэрбум 622,3 сая төгрөг, улсын төсөвт 2 тэрбум 994,4 сая төгрөгийг төвлөрүүлээд байна.

2.2.Татвар төлөлтийн байдал:Татварын орлогын төлөвлөгөө аймгийн дүнгээр 118.2 хувийн биелэлттэй, 10 тэр бум 727.4 сая төгрөгийн орлого оруулсаны цалин хөлс, түүнтэй адилтгах орлого 42.4 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 3.2 хувь, ашигт малтмал ашигласаны төлбөр 22.4 хувь, бусад нэр төрөл 32.0 хувийг тус тус эзэлж байна. Нийт татварын орлогын бүрдүүлэлтийн 72.0 хувь буюу 7 тэрбум 729.9 сая төгрөгийг орон нутгийн орлого, 28.0 хувь буюу 2 тэрбум 997.5 сая төгрөгийг улсын төсвийн орлого бүрдүүлж байна.

Монгол банкны мэдээгээр эхний 11 сарын байдлаар гүйлгээнд 5 тэрбум 240.5 сая төгрөг, иргэдийн мөнгөн хадгаламжинд 64.5 мянган иргэний 68.2 тэрбум төгрөг байгаа нь иргэдийн мөнгөн хадгаламж өнгөрсөн оны мөн үеэс 7.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. Аймгийн дүнгээр 112.4 тэрбум төгрөгийн зээл олгосон нь өнгөрсөн оны мөн үеэс 10.7 хувь буюу 10.9 тэрбум төгрөгөөр өссөн байна. Зээлийн сарын хүүг арилжааны банкуудаар авч үзвэл дунджаар ХААН банк 1.82%, Хас банк 0.58-2.0%, Төрийн банк 1.66%, Капитал банк 1.5% байна.

Гурав. Хууль зүйн бодлогын хүрээнд:

3.1. Хууль хяналтын үйл ажиллагаа: Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын удирдлагуудын уулзалтыг 2017.12.01-ний өдөр нутгийн удирдлагын ордны 2 давхарын хурлын зааланд зохион байгууллаа. Энэхүү хуралдаанаар “Эрх зүйн боловсрол-Эрс өөрчлөлт” дэд хөтөлбөрийн

хүрээнд Олон улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан 2017 оны 12 дугаар сарын 8,13 –ны өдөр иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх арга хэмжээ зохион байгуулах талаар байгууллагуудын дарга нараас саналыг авч хэлэлцлээ. Байгууллагуудын удирдлагууд сумдуудаар хийх хууль сурталчлах, урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах үйл ажиллагааны хүрээнд байгууллага тус бүрээс ажилтангууд авч сургалтын нэг баг болгож ажиллах санал гарсан. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байрны хоригдлуудын амьдрах орчныг сурталчлах зорилгоор телевизийн нэвтрүүлэг бэлдэх ажлыг зохион байгуулах санал гаргаж дэмжигдсэн.

“ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛ-ЭРС ӨӨРЧЛӨЛТ” дэд хөтөлбөрийн хүрээнд олон улсын хүний эрхийн өдрийг тохиолдуулан иргэдэд хууль зүйн өгөх арга хэмжээг 2017 оны 12 дугаар сарын 8,13-ны өдрүүдэд Завхан аймгийн Улиастай сумын баруун бүсийн худалдааны төв, аймгийн Төрийн банкны зааланд зохион байгуулж ажиллалаа. Энэхүү арга хэмжээний үндсэн зорилго нь

1.Эрх зүйн боловсрол-Эрс өөрчлөлт дэд хөтөлбөрийн хүрээнд Олон Улсын Хүний эрхийн өдрийг тохиолдуулан иргэдэд тулгамдаж буй хууль зүйн үр дагавар бүхий бэрхшээл, түүнийг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх зорилгоор хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээ, мэдээлэл өгөхөд энэхүү арга хэмжээний зорилго оршино.

2. Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “а”-д “хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах”, “Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.2 дахь хэсэг “Хүний эрхийг хангах, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлд төрийн байгууллагуудын ажлын уялдааг хангаж, эрх зүйн сургалт, сурталчилгааны хүртээмжийг нэмэгдүүлнэ.” Гэсэн зорилтын 1 дэх заалтын дагуу иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгууллаа.Үүнд: -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, Аймгийн Прокурорын газар, Шүүхийн Тамгын газар, Хууль зүй дотоод хэргийн яамны эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагууд / саналаар/, Хүний эрхийн Үндэсний комисс, Улсын бүртгэлийн хэлтэс, Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгч, Монголын Хуульчдийн холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Орон нутаг дахь телевизүүд оролцож иргэдэд үйл ажиллагаагаа сурталчилан зөвлөгөө өгч ажилласан.

Өдөрлөгийн хүрээнд эрх зүйн мэдээлэл хайх, олж авах эрх зүйн байдлаа хамгаалах боломж бололцоог нэмэгдүүлэх талаар иргэдэд туслах, иргэдэд үнэ

төлбөргүй хууль зүйн зөвлөгөө өгөх, УИХ-аас батлагдан гарч буй хууль тогтоомжийг сурталчлах арга хэмжээг зохион байгууллаа.

Өдөрлөгөөр 2 өдөр 141 иргэн байгууллагуудын төлөөллөөс зөвлөгөө авсан бөгөөд нийт 8 байгууллагын 13 ажилтан, албан хаагчид энэхүү өдөрлөгт оролцож иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгч ажиллаа.



Мөн "Хууль зүйн зөвлөгөө өгөх өдөрлөг"-ийн хүрээнд Улиастай сумын баг тус бүрээс нийгмийн идэвхтэй 6 иргэнийг сонгож Завхан аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын шинээр ашиглалтанд орсон цагдан хорих байрыг танилцууллаа.



3.2.Гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл: Цагдаагийн газарт иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 20 гомдол мэдээлэл хүлээн авч шалгасны 5 буюу 25,0 хувь нь гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл, 15 буюу 75,0 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл хүлээн авч цагдаагийн алба хаагчийн ирүүлсэн 6 зөрчил бүртгэгдсэн байна. Гомдол мэдээллийг өмнөх сартай харьцуулахад 1 нэгж буюу 0,9 хувиар буурсан байна. Гэмт хэргийн шинжтэй 5-н гомдол мэдээллийн хулгайлах гэмт хэрэг 3 гарснаас малын хулгай-3, золгүй байдлаар нас барсан-1, хүчиндэх-1 гэсэн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл

бүртгэгдсэн байна. Мал хулгайлах гэмт хэрэг буурахгүй байна. Зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 15 бүртгэгдсэн нь өмнөх сартай харьцуулахад ижил түвшинд байна. Зөрчлийг гомдол хэрүүл маргаан үүсгэсэн дуудлагаар-10, танхайрах-2, хүчиндэх зөрчил-1, Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гомдол мэдээлэл 2 бүртгэгдсэн байна.

Замын цагдаагийн чиглэлээр:

Энэ хугацаанд, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 6 зөрчил илрүүлж ажилласан байна. Зөрчил гаргасан 131 иргэнийг 2,985,000/ хоёр сая есөн зуун наян таван мянган/ төгрөгөөр зөрчлийн тухай хуулийн дагуу торгож, Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн ахуйн хүрээнд архидан согтуурч, бусдын амгалан тайван байдал алдагдуулсан 8 иргэнийг эрүүлжүүлэх байранд хүргэж, шүүгчийн захирамжаар 7 иргэнийг баривчлав. Өмнөх сартай харьцуулахад эрүүлжүүлэгдсэн хүн 7 хүнээр 2,1 хувиар буурсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 6 багт хөдөлгөөнт эргүүл 252 хүн цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж 152 цэг салбар шалгаж, 106 иргэн аж ахуйн нэгж байгууллагад ухуулга яриа хийж “Мал нэгдсэн” арга хэмжээнийх хүрээнд 8 чиглэлд 24 цагийн пост ажиллалаа.

3.3.Архивын ажлын мэдээлэл: 2 хөмрөгийн удирдлагын баримт бичгийг баримтын түвшинд тодорхойлон бичилт хийж, тоо бүртгэлийн програмд 29хн, 1642 хуудас баримтаас 1226 заалт, 3911 хүний нэр 29 PDF файл үүсгэн эх баримтыг мэдээллийн санд холболоо.

Ашиглалтын хувь үүсгэх ажлын хүрээнд 3 хөмрөг, 3 данс, 50 хадгаламжийн нэгжийн 3111 хуудас баримтыг сканердаж, 3 хөмрөг 3 дансны 50 хадгаламжийн нэгж, 3111хуудас баримтыг photoshop програмд засварлаж ашиглалтын хувь үүсгэсэн.

3 хөмрөгийн 303 хадгаламжийн нэгж баримтанд иж бүрэн нягтлан шалгалт, дахин боловсруулалт хийж, үдэж хавтаслан холбогдох акт үйлдэж, данс бүртгэлд оруулсан.

Иргэн, байгууллагын 213 иргэний хүсэлтийг хүлээн авч лавлагаа 193, хуулбар 464, тодорхойлолт 95 олгож төрийн үйлчилгээ үзүүллээ.

Төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх төлөвлөгөөний дагуу 1 хөмрөг үүсгэгчээс байнга хадгалах 29 хадгаламжийн нэгжийг нягтлан шалгаж хүлээн авч, захирамжлалын 7 хадгаламжийн нэгж баримтыг цахим хэлбэрт оруулсан.

3.4. Онцгой байдал: Өвөлжилтийн бэлтгэл байдлыг хангаж Улиастай сум дахь өвс тэжээлийн цэгт 50.0 тн, Тосонцэнгэл сум дахь өвс тэжээлийн цэгт 100.0

тн, Тэс сум дахь өвс тэжээлийн цэгт 50.0 тн, Шилүүстэй сум дахь өвс тэжээлийн цэгт 50.0 тн Завханмандал сум дахь өвс тэжээлийн цэгт 50.0 тн нийт-300.0 тн өвсийг нөөцлөөд байна.

Мөн нэмэлт нөөц бүрдүүлэлтээр Тосонцэнгэл сум дахь өвс тэжээлийн цэгт 200.0 тн тэжээлийг нөөцөллөө.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн 314 дүгээр тогтоолын дагуу Түдэвтэй сум дахь өвс тэжээлийн цэгийг түр цэг болгосонтой холбогдуулан Онцгой байдлын газрын даргын А/43 тоот тушаалаар томилогдсон ажлын хэсэг 2017 оны 12 дугаар сарын 18-21-ны хооронд агуулах саравчны бүрэн бүтэн байдал, цэвэрлэгээ үйлчилгээ хангах зорилгоор Түдэвтэй сумын засаг даргын тамгын газартай хамтран ажиллаж бараа материалын хадгалалтын чанар, технологид хяналт тавин стандартын дагуу агуулахад хивэг 200.0 тн, хорголжин 50.0 нийт 250.0 тн тэжээлийг нөөцлөх ажлыг хийж гүйцэтгэлээ.

Аймгийн Засаг даргын 2017 оны А/334 дүгээр захирамжаар Гамшгийн үед иргэдийн цугларах талбай, түр орогнох байр, нүүлгэн шилжүүлэлт хийх газруудын кадастарын зурагт оруулан гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд хавсаргасан.

2017 оны 12 сард аймгийн Онцгой комиссыг 1 удаа хуралдуулсан.



Аймгийн онцгой комиссыг цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан 1 удаа хуралдууллаа. Хурлаар: Тус аймгийн Өвөлжилтийн нөхцөл байдалтай танилцахаар ХХААХҮЯамнаас ажлын хэсэг ирж сумдаар ажиллаж

ажилласан талаар аймгийн Онцгой комиссын гишүүдэд мэдээлэл хийж үүрэг даалгавар өгсөн.

Аймгийн Онцгой комиссоос 2017 онд авч хэргэжүүлсэн ажлын тайланг гаргаж Монгол Улсын Шадар сайдын ажлын албанд хүргүүлсэн.

2017 оны 12 сарад төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар Улсын бүртгэлийн хэлтэс, Оргил худалдааны төв, Алтан, Чигэстэй, Загастай, Загсан нүд зоогийн газар зэрэг 6 газарт Галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, норм стандартын хэрэгжилтийг хангуулах хяналт шалгалтыг зохион явууллаа.

Шалгалтаар: Объектод байх гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг зайлшгүй байх шаардлага норм, нормативын дагуу байрлуулаагүй, ажилчидад гамшгаас хамгаалах сургалт, дадлага зохион байгуулаагүй, авралтын зам гарцын схем зураг, галын аюулаас урьдчилан сэргийлэх самбар, санамжийг байрлуулаагүй, аваарын гэрэлтүүлэг суурилуулаагүй, гэрэлтүүлэг, чимэглэл нь цахилгаан байгууламжийн дүрэм, журамд бүрэн нийцээгүй зэрэг зөрчил дутагдалууд илэрлээ.

Дээрхи зөрчил дутагдлуудыг арилгуулахаар байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 4 хүргүүлж, шалгалтын дүнгийн талаар шалгалтад хамрагдсан газруудын удирдлагуудад танилцуулж, зөрчлийг арилгах талаар мэргэжил арга зүйн заавар зөвлөмж өгч ажиллаа.

Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

4.1.Боловсролын чиглэлээр: Улиастай сумын ерөнхий боловсролын I-V ангийн суралцагчдын дунд зохион байгуулах STEM боловсролын бүтээлийн үзэсгэлэнг 2017 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Улиастай сумын ЧЭЛС-I сургуулийн урлаг зааланд зохион байгуулж, 5 сургуулиас 8 хүний бүрэлдэхүүнтэй 5 багийн нийт 10 багш, 30 суралцагч оролцож, суралцагчид 3 ангиллаар хийсэн бүтээлээрээ үзэсгэлэн гаргаж, мэндчилгээ дэвшүүлж, 1-2 улиралд хэрэгжүүлсэн ажлын туршлагаа солилцож, сайн туршлагаа түгээн дэлгэрүүлсэн, харилцан туршлага судалсан байна.

Бага ангийн суралцагчдын бие бялдрыг гимнастикийн дасгал хөдөлгөөнөөр хөгжүүлэх, тэднийг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулах зорилгоор IV ангийн суралцагчдын дунд 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан уран хөдөлгөөнт гимнастикийн аварга шалгаруулах тэмцээнийг биеийн тамир, спортын газарт амжилттай зохион байгуулав. Тэмцээнд ерөнхий боловсролын IV ангийн нийт 147 суралцагч оролцож авьяас чадвараа сорилоо.

Хүүхэд багачуудыг ном унших дадал хэвшилтэй болгох, хуучны болон орчин үеийн зохиолуудыг уншуулах, номтой зөв боловсон харьцаж сургах, олон нийтийн газар биеэ зөв боловсон авч явах дадал хэвшилд суралцуулах зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн V ангийн суралцагчдын дунд хүүхдийн заавал унших 10 зохиолоор АХА тэмцээнийг 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Б.Явуухулангийн нэрэмжит төв номын санд амжилттай зохион байгуулж, ерөнхий боловсролын 5 сургуулийн нийт 78 суралцагч амжилттай оролцож Улиастай сумын бүрэн дунд Дэвшил сургуулийн 5в ангийн суралцагчид бусдыгаа хошуучилж алт, мөнгө, хүрэл медалийн эзэд боллоо.

БСШУСЯ-д орон нутгийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг сургуулийн автобусаар тээвэрлэж буй судалгааг гарган хугацаанд нь хүргүүллээ.

Судалгаанаас дүгнэхэд: Тосонцэнгэл сумын бүрэн дунд I сургууль, Идэр сумын бүрэн дунд сургууль, Их-Уул сумын бүрэн дунд сургуулиуд автобустай боловч, аймагт болох урлаг, спортын наадам, олимпиад, уралдаан тэмцээнд оролцуулахаар сурагчдаа аймаг сумын хооронд тээвэрлэдэг. Улиастай сумд байрлах ерөнхий боловсролын 5 сургууль Улиастай сумын ЗДТГазрын харьяа автобусаар сурагчид нь зорчдог байна.

“Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг 2017 оны 12 дугаар сарын 19-ны өдөр БСШУСЯ-д хүргүүллээ. Үдийн цай хөтөлбөрт 2016-2017 оны хичээлийн жилийн 2-р хагаст ерөнхий боловсролын 29 сургуулийн бага боловсролын 7454 суралцагч, багш ажилтнууд, мэргэжлийн 62 тогооч хамрагдан 655.5 сая төгрөг зарцуулсан байна.

Цэцэрлэг, сургуулиуд үдийн цай хөтөлбөрийг хяналтын зөвлөлийн гишүүдийн оролцоотой эцэг эх, суралцагч, багш нараас сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгаанд тулгуурлан үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.

2017 оны 12 дугаар сарын 20-нд Улиастай сумын бүрэн дунд ЖЦС-II сургууль дээр эцэг эхчүүдийн дунд зохион “Өртөөчилсөн сургалт”-ын үйл ажиллагаанд 5-р ангийн нийт 120 эцэг эхчүүд 5 бүлэгт хуваагдан Математик, Дүрслэх урлаг, STEM боловсрол, Хүн ба байгаль, Хүн ба нийгмийн хичээлд сууж эргэн хүүхэд насандаа очиж дурсамж дүүрэн өдрийг өнгөрөөлөө.

Энэхүү өртөөчилсөн сургалтын үр дүнд эцэг эхчүүд хүүхдийнхээ цүнхний ариун цэвэрт анхаарах, хичээлийн хэрэгслийг бүрэн бэлтгэж өгөх шаардлагатай гэдгийг ойлгож, ухаарлаа.

Байгууллагын бичиг хэргийн зарцуулалтанд хяналт хийв. Зарцуулалтаас нь харахад сар бүрийн гол хэрэглээ нь бичгийн цаас, хор, цэнэглэгч хор, шохойтой цаас гэсэн хэдэн төрлийн бараанд ихэнх бичиг хэргийн зардал зарцуулагдаж байна.

Байгууллагын өөрийн орлого, түүний зарцуулалтанд хяналт хийж ажиллалаа. 2017 онд кабинетийн гэрчилгээ 138, заах аргач зэргийн -118 үнэмлэх, тэргүүлэх зэргийн-79 үнэмлэх нийт 335 гэрчилгээ, үнэмлэхний 1675000 төгрөг, төгсөлтийн бичиг баримтны 300000 төгрөг бүгд 1975000 төгрөгний орлого орсон байна. Үүнээс зарлага нь хэвлэлд-295500, бичиг хэрэгт-88000, багш нарын баярт-746000, шинэ жилд-219000, олимпиадад-65000, бусад зардалд-561500 төгрөг зарцуулагдсан

байна. Байгууллагын өөрийн орлого, зарлагад хяналт хийхэд зарцуулалт нь маш тодорхой, цэгцтэй байна.

4.2. Эрүүл мэнд, спортын чиглэлээр: Аймгийн хэмжээнд 2017 оны эхний 11 дүгээр сард 1222 эх амаржиж, амьд төрсөн хүүхэд 1230 болж, өмнөх оны мөн үеэс амаржсан эх 93 (7.1%)-аар, амьд төрсөн хүүхэд 92 (7.0%)-оор буурсан байна. Энэ оны 11 дүгээр сард 122 эх амаржиж, 120 хүүхэд төрүүлсэн нь өмнөх сараас амаржсан эх 16 (15.1%)-аар, хүүхэд 14 (13.2%)-өөр нэмэгдсэн байна.

Нялхсын эндэгдэл эхний 11 дүгээр сард 22 болж, өмнөх оны мөн үеэс 1 (4.8%)-ээр нэмэгдсэн байна. 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин 17.9 болж, өмнөх оноос 2.0 пунктээр өссөн байна.

“Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил”-ийн хүрээнд **“Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүнг сайжруулах нь” сэдэвт** сургалтыг эрүүл мэндийн байгууллагуудын төлөөлөл 90 хүнд Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв Эрүүл мэндийн газартай хамтран зохион байгууллаа.

Халдварт өвчний тархалт, урьдчилан сэргийлэлт, эрсдэлийн үнэлгээний талаарх 1 өдрийн сургалтыг Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс зохион байгуулж сургалтанд Эрүүл мэндийн газар, сум өрхийн удирдлагууд, сумын нийгмийн эрүүл мэндийн арга зүйчид 46 хүнийг хамрууллаа.

НҮБ-ын хүн амын сангийн дэмжлэгээр “Олон нийтэд түшиглэсэн Хүүхдийн өвчний цогц менежмент” сургалтыг 24 сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч эмч, нийгмийн эрүүл мэндийн арга зүйч 60 хүнд сургалт зохион байгуулж сумын түвшинд ажиллах сургагч багш нарыг бэлтгэсэн байна.

АШУУИС-ын Хүүхдийн анагаахын тэнхимийн багш, хүүхдийн ерөнхий мэргэжилтэн, мэргэжилтэнүүдтэй хамтран сум, өрхийн 80 их эмч, багийн бага эмч нарт хүүхдийн өвчний эрэмбэлэн ангилалт, томуу, томуу төст өвчний эмнэл зүйн удирдамж, хүүхдийн тусламж үйлчилгээнд хэрэглэж буй анхан шатны маягтын хөтлөлт, өвчний түүх бичилтийн талаар сургалтыг зохион байгуулж эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр, хүүхдийн өвчний түүхэнд үнэлгээг хийлээ. Мөн Улиастай сумын 1-р цэцэрлэгийн 379 хүүхдийн өсөлт хөгжилтын байдалд хамтран үнэлгээ хийж байна.

Улиастай суманд үйл ажиллагаа явуулж байгаа 5 эмийн санд эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй олгодог эмийн хүртээмж хангамж, үнийн ил тод байдал, жор бичилтэнд хяналт үнэлгээ хийсэн. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Эм хангамж, Тосонцэнгэлийн Нэгдсэн эмнэлэгт мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн орлого,

зарлагын бүртгэл, хадгалалт, жор бичилтийн стандартад хяналт үнэлгээг хийж зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

2017 оны 12 сарын 20-ны байдлаар өөр аймаг, сумын нутагт отор нүүдлээр явж байгаа 555 иргэн байгаа бөгөөд үүний дотор байгаа 5 хүртэлх насны 81 хүүхэд, жирэмсэн 11 эх, хөгжлийн бэрхшээлтэй 44 иргэн, 390 ахмад настанд хүргэх эмнэлгийн тусламжийн нөөцийн хангалтыг тооцож сумын эрүүл мэндийн төвүүдэд үүрэг чиглэл өгч үүрэгжүүлж ажиллаж байна. Эдгээр иргэдэд хүргэх зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж 79,9%, түргэн тусламжийн авто машины түлш шатахуун сумдад хүрэлцээтэй байна. Геронтологийн үндэсний төв, аймгийн Эрүүл мэндийн газар, аймгийн Ахмадын хороотой хамтран “Жавхаат хэмнэл” аэробик дасгалын сургагч багш бэлтгэх сургалтад Улиастай сумын 6 баг, Алдархаан сумын 18 ахмадыг сургаж багшлах эрхтийн гэрчилгээг олголоо.

Нийтийн биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулах, эрчимжүүлэх тухай аймгийн Засаг даргын 2017 оны А/28 дугаар захирамжийн хэрэгжилтийн хүрээнд 12 дугаар сард 12 дах удаагийн арга хэмжээ болох бүх нийтийн явган аялалыг зохион байгууллаа. Явган аялалд төрийн болон аж ахуй нэгж байгууллагуудын төлөөлөл 400 гаруй иргэд оролцож далайн түвшнээс дээш 2500 м-т орших Товцог хайрхан ууланд гарсан.

Улиастай сумын 9-н цэцэрлэгийн багш ажилчид, 6 багийн ахмадуудын дунд бүжгийн тэмцээн, ажлын байрны дасгалыг хэн нь сайн хийх вэ тэмцээнийг зохион байгуулж нийт 180-аад ахмад, багш нар оролцож шилдэг оролцогчдыг шалгаруулж шагнаж урамшууллаа.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017.11.10-ны өдрийн 1а/10658-р албан тоотоор өгөгдсөн чиглэлийн дагуу Биеийн тамир, спортын салбарын улсын нэгдсэн тооллогыг Завхан аймагт зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын А/438-р захирамжаар байгуулан ажиллаж байна. Аймгийн хэмжээнд тооллогч 86, ахлагч 24, аймаг, сумын ажлын хэсэг нийт 122 хүний бүрэлдэхүүн ажиллаж судалгааны явц 70 %-тай байна.

Аймгийн Засаг даргын дэргэд өсвөрийн шигшээ багийг 8 төрлөөр хичээллүүлэн анх удаа аймагтаа “Сурагчдын лиг-2017” өсвөрийн сагсан бөмбөгийн тэмцээнийг сарын хугацаатай зохион байгууллаа. Хүүхдүүдийн ур чадварыг хөгжүүлсэн бусдад нөлөөлөхүйц олон нийтийн анхаарлыг татсан тэмцээн болж ЧЭЛС-ийн баг тамирчид тэргүүлж, Дэвшил, ЕБС-ын 3 дугаар сургуулийн баг тамирчид I, III байрыг эзэлсэн.

НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

Аймгийн хэмжээгээр нийгмийн даатгалын сангаас эхний 11 сард 10.1 мянган хүнд 34.7 тэр бум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгож, 14.2 тэр бум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Эхний 11 сард 10755 хүн нийгмийн даатгалд хамрагдсаны 6997 буюу 65.1 хувь нь төсөвт байгууллага ААНэгж байгууллагын даатгуулагч, 3758 иргэн буюу 34.9 хувь нь сайн дурын даатгалд хамрагдсан байна.

Сангуудаар авч үзвэл: ҮОМШӨ сангийн орлогын төлөвлөгөөг 30.1 хувиар давуулан биелүүлж, тэтгэврийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 0.2 хувиар, тэтгэмжийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 9.4 хувиар, эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 3.7 хувиар, ажилгүйдлийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 10.4 хувиар тасарсан байна.

Тэтгэвэрийн сангийн зарлага 29992.2 сая төгрөгт, Тэтгэмжийн сангийн зарлага 1137.7 сая төгрөг, Эрүүл мэндийн сангийн зарлага 3049.5 сая төгрөг, ҮОМШӨ-ний зарлага 41.4 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалийн сангаас 474.7 сая төгрөг тус тус зарцуулж нийт 34695.5 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, даатгалыг олгосон байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 2017 оны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүнг хянан үзээд ажилгүй, орлого багатай иргэдийг зохион байгуулалттай түр ажлын байраар хангаж, орлогоор дэмжих зорилгыг хэрэгжүүлэхээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 134 сая төгрөг хуваарилагдаж, 13 сумын 17 төслийг санхүүжүүллээ.

Зохион байгуулалттай түр ажлын байраар хангах ажлын хүрээнд өвөлжилт хүндэрч болзошгүй, хүндэрсэн сумдын 33 малчин өрхийн өвөлжөө засварлаж хөрзөн ховхолж, 3 нялдгааны цэг цэвэрлэж, 400 тн өвс тэжээл буулгаж, 4 тарилга туулгын хашаа барьж, цасанд боогдсон 4 даваа онгойлгож, 3 зам талбайн цас цэвэрлэж, нурж эвдэрсэн 2 гүүр засч сайжруулан ажлуудыг зохион байгуулж, 521 иргэнийг түр ажлын байраар хангаж, өрхийн орлогыг нэмэгдүүллээ.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй хүний тоо 1131 болж, өнгөрсөн оны мөн үеэс 4.4 хувиар буюу 52 хүнээр буурсан байна. Аймгийн хэмжээнд 625 эмэгтэй ажил идэвхитэй хайж байгаа нь ажилгүйчүүдийн 52.3 хувийг эзэлж байна.

2017 оны 11 сарын байдлаар бүртгүүлсэн, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүйчүүдийн тоо өмнөх 4 жилийн дунджаас 4.3 хувиар буюу 52 хүнээр буурсан байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 15.9 хувь нь 15-24 нас, 34.4 хувь нь 25-34 нас, 24.9 хувь нь 35-44 нас, 21.0 хувь нь 45-54 нас, 3.4 хувь нь 55-59 нас, 0.3 хувь нь 60 дээш насны ажилгүйчүүд байна.

Ажилгүйчүүдийн 1.7 хувь нь боловсролгүй, 2.5 хувь нь бага, 8.0 хувь нь суурь, 48.4 хувь нь бүрэн дунд, 6.2 хувь нь техникийн болон мэргэжлийн, 5.6 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 27.6 хувь нь дээд боловсролтой хүмүүс тус тус эзэлж байна.

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖИЛ

Хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах НЭГДҮГЭЭР ХҮҮХЭД аян “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”, ДОХ-ын эсрэг өдөр, ХБИ-ийн эрхийг хамгаалах өдрийг 11 дүгээр сарын 25-наас 12 дугаар сарын 10-ны хооронд хамтатган дараах зорилтуудын хүрээнд зохион байгууллаа. Үүнд:

- Хүчирхийллийг тэвчихгүй байхыг, нуугдмал чимээгүй байдлыг халахын төлөө хүн бүр дуугарч эхлэхийг уриалах;
- Охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоохын төлөө хүн бүр дор бүрнээ жижиг ч болтугай алхам хийх, санаачилга гаргахыг дэмжих, хүчээ нэгтгэн ажиллах боломжоор хангах;
- Хүн бүрийн аюулгүй байдлыг хангах, эрх, эрх чөлөөг хамгаалах үүрэг, амлалтаа биелүүлэх, хуулиа хэрэгжүүлэхийг төр, засгийн газраас шаардах

Аяны хүрээнд ГБХЗХГ-ын дэргэдэх “SASA Завхан” клубын сайн дурын активистууд айл өрхүүдийг сайн хөршийн холбоо үүсгэх замаар гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, мэдээллэхэд иргэдийн оролцоог бий болгох, эмэгтэйчүүд хүүхдүүдэд хүчирхийллийн эрсдэлт хүчин зүйлээс өөрсдийгөө хамгаалах боломжийг нэмэгдүүлэх зорилго бүхий “Айл хүний амь нэг” хөтөлбөрт арга хэмжээг ДЗМОУБ-ын “Завханхангай” ОНХ, Улиастай сумын 4 баг, Улиастай сумын ерөнхий боловсролын 4-р сургууль, Онцгой байдлын газар, Завхан телевиз зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгуулсан.

“Айл хүний амь нэг” хөтөлбөрт арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг зохион байгууллаа.

- 12 дугаар сарын 05-нд SASA активистүүдийн уулзалт;

- 12 дугаар сарын 07-10-ны өдрүүдэд олон нийтэд хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар ойлголт, мэдлэг өгөх 18 минутын “Охин” баримтат кино болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн агуулгаар хийсэн 3 төрлийн богино хэмжээний дүрс бичлэгийг орон нутгийн телевизээр нэвтрүүлэх;
- 12 дугаар сарын 09-ны өдөр айл, өрхүүдээр нөлөөллийн ажил хийх /цагаан туузны утга учрыг тайлбарлан өгч, зүүж өгөх, танилцуулга материал тараах, гарын үсэг зуруулах, 108 утас, хүүхэд хамгааллын мэдээлэл өгөх, судалгаа авах...гм/;
- 12 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд “Хүч чадал хүчирхийлэлд зориулагдаагүй!” хэлэлцүүлэг зохион байгуулах;
100 өрхийн 400 гаруй хүн, 100 гаруй төрийн албан хаагч нийт 500 гаруй хүнд “Аливаа хүчирхийллийн дэргэдүүр чимээгүй өнгөрөхгүй, хэзээ ч хүчирхийлэл үйлдэхгүй” гэдгийн илэрхийлэл болсон цагаан туузыг зүүн өгч энэхүү аяндаа нэгтгэсэн. Мөн дунд сургуулийн эцэг эх, төрийн тусгай албан хаагч нийт 60 хүнийг хамруулсан “Хүч чадал хүчирхийлэлд зориулагдаагүй” хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Орон сууцны айлуудын 56 орцоор хүүхэд хамгааллын зурагт хуудсыг байрлуулсан.

Нийт 560 гаруй хүнийг хамруулсан энэхүү үйл ажиллагааны үр дүнд олон нийтийн орчин дахь хүүхэд хамгаалал бэхжиж, гэр бүлийн хүчирхийлэл буурахад зохих эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байгаа.

НҮБ-ын Хүүхдийн сангийн Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөрийн 2017 оны тайлангийн хурал Улаанбаатар хотод 2017 оны 12 дугаар сарын 13-14-ний өдрүүдэд зохион байгуулагдсан. Хуралд Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөрийн зохицуулах зөвлөлийн гишүүд оролцож 2017 онд хийсэн ажлын тайланг танилцуулж, 2018 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд санал солилцсон.

Залуучуудын хөгжлийн чиглэлээр:

Нэгдсэн үндэсний байгууллагын хүн амын сан, Швейцарийн Хөгжлийн агентлаг, Люксембургийн Засгийн газартай хамтран хэрэгжүүлсэн төслийн хүрээнд “Залуучуудын хөгжлийг дэмжих” тухай хуулийн танилцуулга, Өсвөр үе залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрт санал авах баруун бүсийн хэлэлцүүлгийг 2017 оны 11 дүгээр сарын 29-30-нд зохион байгууллаа.

Зөвөлгөөнд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга, Залуучуудын алба, хэлтсийн дарга, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн,

залуучуудын хөгжлийн төвийн ажилтан, иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл хамрагдан нийт 80 хүн оролцлоо.

Хэлэлцүүлэгт давхардсан тоогоор нийт 121 санал гарч, үүнээс зарчимын зөрөөтэй болон найруулгын өөрчлөлт оруулах 49 санал тэмдэглэлээр гаргасан бөгөөд бусад саналууд төслийн заалтуудыг дэмжсэн санал байна.

Мөн Залуучуудын хөгжлийн төвийн “Сайн туршлага, сургамж-гарц, шийдэл” танилцуулга илтгэлийн аймаг бүрийн оролцогчид тавьж туршлага солилцлоо.

Энэ үйл ажиллагааны үр дүнд бүсийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, залуучуудын хөгжлийн төвүүдийн мэргэжилтнүүдийн мэдлэг мэдээлэл дээшилсэн, үндэсний хөтөлбөрт өөрсдийн саналаа тусгуулахаар илэрхийлсэн, хамтын ажиллагаагаа идэвхжүүлэхэд ахиц гарах бололцоог бүрдүүлсэн зэрэг эерэг нөхцөл бий боллоо.

Аймгийн эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсны дагуу аймгийн оны шилдэг хүүхдүүдийг шалгаруулж, улсын шилдэг хүүхэд шалгаруулах комисст материалыг хүргүүллээ.

Австри улсын Вена хотноо 2017 оны 3 дугаар сарын 14-25-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Тусгай ОЛИМП-ийн цасны гуталтай гүйлтийн 100 болон 200 метрийн төрөлд хос мөнгөн медаль хүртсэн Завхан аймгийн Улиастай сумын Бүрэндунд IV сургуулийн Насан туршийн боловсролын ангийн суралцагч Батбаярын ОЮУНБИЛЭГ "Биеийн тамир, спорт, бие бялдрын хөгжил" төрөлд **МОНГОЛ УЛСЫН ШИЛДЭГ ХҮҮХДЭЭР ТОДОРЛОО.**

Мөн аймгийн шилдэг хүүхдүүдийг тодордууллаа. Үүнд:

1. Сурлагын амжилт “Оюунлаг-Зөв хүүхэд”-ээр Улиастай сумын Б.Элдэв-Очирын нэрэмжит Чандмань-Эрдэнэ лаборатори сургуулийн 12а ангийн суралцагч Балжиннямын Ариунтунгалаг
2. Урлаг, уран бүтээл “Авьяастан-Зөв хүүхэд”-ээр Тосонцэнгэл сумын Л.Цэндийн нэрэмжит үндэсний лаборатори сургуулийн 12б ангийн суралцагч Наранчулууны Дэлгэрмаа
3. Биеийн тамир, спорт, бие бялдрын хөгжил “Спортлог-Зөв хүүхэд”-ээр Түдэвтэй сумын бүрэн дунд сургуулийн 10а ангийн суралцагч Баттөрийн Ойгонзаяа
4. Биеийн тамир, спорт, бие бялдрын хөгжил “Спортлог-Зөв хүүхэд”-ээр Улиастай сумын Б.Элдэв-Очирын нэрэмжит Чандмань-Эрдэнэ лаборатори сургуулийн 12д ангийн суралцагч Батхуягийн Оюунгэрэл

5. Эх орны түүх, соёл, өв уламжлал “Соёлын өвийг тээгч-Зөв хүүхэд”-ээр Соёл, урлагийн их сургуулийн Завхан аймаг дахь Хөгжим бүжгийн коллежийн 12а ангийн суралцагч Баасангийн Нямлхагва
6. Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллага “Тэргүүний идэвхтэн-Зөв хүүхэд”-ээр Улиастай сумын бүрэн дунд IV сургуулийн 12а ангийн суралцагч Дашпунцагийн Хажидмаа
7. Бүтээлч, ажилч, хичээнгүй байдал, мэргэжлийн чиг баримжаа “Хөдөлмөрч-Зөв хүүхэд”-ээр Монгол улсын Хөдөлмөрийн баатар, гавьяат багш Д.Дагвын нэрэмжит Цэцэн-Уул сумын бүрэн дунд сургуулийн 11а ангийн суралцагч Баттөрийн Мягмарсүрэн
8. Техникийн сэтгэлгээ, шинийг сэдэх, санал санаачилга “Бүтээлч-Зөв хүүхэд”-ээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Завхан аймаг дахь Политехник коллежийн Барилгын техникчийн нэг дүгээр ангийн суралцагч Очирбатын Наранбаатар
9. Байгаль хамгаалал, эрүүл аюулгүй орчин “Эх оронч-Зөв хүүхэд”-ээр Улиастай сумын Б.Элдэв-Очирын нэрэмжит Чандмань-Эрдэнэ лаборатори сургуулийн 12д ангийн суралцагч Баатарын Энх-Амгалан
10. Багийн амжилт “Тэргүүний хамт олон”-оор Б.Баярсайхан дасгалжуулагчтай Цанын баг тамирчид
11. Сайн туршлага түгээгч “Тэргүүний Хүүхдийн оролцооны байгууллага”-аар Улиастай сумын бүрэн дунд III сургуулийн Д.Цэнд-Аюуш багштай, М.Майдар ахлагчтай Сурагчдын удирдах зөвлөл
12. Хүүхдэд ээлтэй үйлчилгээг нэвтрүүлэгч “Тэргүүний Нийгмийн ажилтан”-аар Тосонцэнгэл сумын Л.Цэндийн нэрэмжит үндэсний лаборатори сургуулийн нийгмийн ажилтан Хүрлээгийн Цолмонгэрэл

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:

Газар тариалан: 11-р сарын 1-ний байдлаар 2127.0 тн төмс, 1120.2 тн хүнсний ногоо, 1226.7 тн малын тэжээл, 15374.7 тн байгалийн хадлан, 312.5 тн гар тэжээл, 513.0 тн үр тариа тус тус хураан аваад байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад төмс 190.2 тн-оор буюу 8.2 хувиар, хүнсний ногоо 149.3 тн-оор буюу 11.7 хувиар, ногоон тэжээл 1850.4 тн-оор буюу 60.1 хувиар, байгалийн хадлан 5816.6 тн-оор буюу 27.4 хувиар тус тус буурч, гар тэжээл 52.2 тн-оор буюу 20.0 хувиар нэмэгдсэн байна.

Ургац хураалт, хадлан тэжээлийн мэдээ нь өнгөрсөн оноос буурсан үзүүлэлттэй байгаа нь зуншлага тааруу, гантай байсантай холбоотой гэж үзэж байна.

Аймгийн ЗДТГазар, Дэлхийн зөн ОУБ-ын Завханхангай ОНХХөтөлбөрийн газар, Улиастай сумын ЗДТГазартай хамтран Засгийн газрын 2017 оны 278, 223 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор “Жимс, жимсгэнэ”, “Хүнсний ногоо”



аймгийн дэд хөтөлбөрүүдийг боловсруулан

хэлэлцүүлэгийг 2017 оны 12 сарын 18-ний өдөр зохион байгуулав. Дээрх арга хэмжээнд өрхийн тариан эрхлэгч ногоочдын төлөөлөл, жимс, жимсгэнэ тариалагч нарын зэрэг 60 гаруй

иргэдийг хамруулан зохион байгууллаа.

Бага насны хүүхдийн хоол тэжээлийн нэр төрлийг нэмэгдүүлэх “Үдийн цай” хөтөлбөрт нийлүүлэгдэж буй хоолны нэр төрлийг нэмэгдүүлэх, илчлэг тодорхойлох сэдэвт сургалтыг Улиастай, Цагаанчулуут сумдын насан туршийн боловсролын төвүүдтэй хамтран зохион байгууллаа. Уг сургалтанд 2 сумын 45 бага насны хүүхэдтэй ээжүүдийн төлөөлөл хамрагдаж, Хүнсний тухай хууль, Хүнсний аюулгүй байдал, зөв зохистой хооллолтын талаар мэдээллээр хангагдахын зэрэгцээ, бага насны хүүхдийн нэмэгдэл 10 нэр төрлийн хоолыг үйлдвэрлэх арга технологид суралцаж, гарын авлага материалаар хангасан. Орон нутагт ажиллаж байгаа 31 тогоочийн зэргийн түвшинг нэмж, ажлын байрыг баталгаажууллаа.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын 30 –ний өдрийн 93 дугаар тогтоолоор “ЭРҮҮЛ ХҮНС-ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” дэд хөтөлбөр батлуулсан. Хөтөлбөрт 3 зорилтын хүрээнд 41 заалт хэрэгжүүлэхээр тусгагдсан бөгөөд хөтөлбөрийг боловсруулах явцад 16 ажил 30-50%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна.

Бог малын мялзан өвчний вакцинжуулалтын тайланг 13 сумын 31 мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжүүдээс хүлээн авч нэгтгэн Улсын мал эмнэлэг, үржлийн газарт хүргүүлэн үйлчилгээний хөлсийг 100 хувь олгууллаа.

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 257, 284 дугаар тогтоол, МЭҮГазрын даргын 2017 оны А/46 дугаар тушаал зэргийг үндэслэн аймгийн Засаг даргын 2017 оны А/432 дугаар хяналтын цэг ажиллуулах тухай захирамжийг гаргуулан ажиллаж байна. Уг хяналтын цэгийг Их-Уул сумын Цэцүүх багийн Солонготын даваанд хуваарь гарган ажиллаж байна.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:

6.1. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр: UN-REDD⁺ хөтөлбөрийн хүрээнд “Ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэх” арга хэмжээг ойн мэргэжлийн байгууллагууд, нөхөрлөлийн гишүүдэд таниулах сургагч багш бэлтгэх сургалтанд АЗДТГ, БОАЖГ, Тосонцэнгэл сумд дахь Сум дундын ойн ангийн 4 мэргэжилтэнг хамруулсан.

Баянхайрхан суманд үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж буй ШТС, Улиастай сумын Жинст багт үйл ажиллагаа явуулж байгаа “ЭЛ СИ БИ” ХХК-ийн 2 уурын зуух, Их-Уул сумын “Цагаан уулын хишиг” ХХК-ны ойд арчилгаа цэвэрлэгээ хийх, мод модон материал бэлтгэх төсөлд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлээ.

“Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын хэрэгжилтийн дэлгэрэнгүй тайлан, 2017 онд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого, зарлагын тайлангийн мэдээг БОАЖЯаманд холбогдох маягтын дагуу гарган хүргүүлсэн.

Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч Баян-Айраг Эксплорэйшн ХХК, Форс голд майнинг ХХК-уудын 2017 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дүгнэх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/395 дугаар захирамжаар байгуулж, 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдөр дүгнэж, дүгнэлтийг БОАЖЯаманд хүргүүлсэн.

Завханмандал сумын нутагт XV-018161 хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий “Хага” нэртэй талбайд 2017 онд гүйцэтгэх геологийн хайгуулын ажлын үеийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянаж, баталгаажуулсан.

6.2. Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл эхний 11 сарын байдлаар оны үнээр 11791.2 сая төгрөг болж, өнгөрсөн оноос 30.1 хувиар буюу 2725.2 сая төгрөгөөр өссөн нийт үйлдвэрлэлээс ААНэгжийн үйлдвэрлэл нь 6262.7 сая төгрөг, иргэдийн үйлдвэрлэл

нь 5528.5 сая төгрөг болсон байна. Үйлдвэрлэлд цахилгаан, дулаан, усан хангамжийн үйлдвэрлэл 41.7 хувийг, хүнсний үйлдвэрлэл 32.5 хувь, хувцас үйлдвэрлэл 13.1 хувь, модон эдлэл үйлдвэрлэл 9.5 хувь, эсгий эдлэл үйлдвэрлэл 0.7 хувь, өлөн гэдэс үйлдвэрлэл 0.3 хувь, барилгын ханын материал үйлдвэрлэл 1.0 хувь, вакум цонх үйлдвэрлэл 0.5 хувь, бусад үйлдвэрлэл 0.7 хувийг тус тус эзэлж байна.


6.3. Дэд бүтцийн чиглэлээр:

2017 оны 12 сарын 12-14-ний өдрийн хооронд Газар зохион байгуулалт, геодези зурагзүйн газар, “Ногоон алт-малын эрүүл мэнд” төсөлтэй хамтран “Бэлчээрийн фотомониторингийн үр дүнг Ленд менежер программд оруулах” сэдэвт сургалтыг 254 сумын газрын даамлуудыг хамруулан зохион байгууллаа.



Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний техникийн тодорхойлолт боловсруулах ажлын хэсгийг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ГЗБГЗЗГ-тай хамтран Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө хийлгэх ажлын даалгаварыг боловсруулж ГЗБГЗЗГазрын дарга, аймгийн Засаг даргаар батлуулсан.

2017 оны 04 сарын 04-ны өдөр Аймгийн Орон нутгийн өмчийн газарт ажлын даалгаврыг хүргүүлж тендер зарлуулж уг тендерт 4 компани оролцсноос "Тэгшхэмгрупп" ХХК шалгарч аймгийн Засаг даргатай 2017 оны 06 сарын 16-ны өдрийн ГЗБ 01/2017 ажилгүйцэтгэх гэрээг байгуулж 2017 оны 06 сарын 19-ны өдрөөс 2017 оны 07 сарын 24-ний өдрийн хооронд суурьсудалгааг ГХБХБГазартай хамтран бүрэн хийгдэж төлөвлөгөөний



төслийг боловсруулан Бэлчээрийн үндэсний форум, Ногоон алт төсөл, ГЗБГЗЗГ болон аймгийн ЗДТГ дээр нийт 4 удаа хэлэлцүүлэг зохион байгуулж саналыг авч төлөвлөгөөнд тусгах ажлыг зохион байгуулсан. 2017 оны 12 сарын 04 өдрийн аймгийн ИргэдийнТөлөөлөгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж батлууллаа.

Монгол орны баруун бүсэд газрын доройтол хөгжлийн сөрөг нөлөөллийг бууруулах дүйцүүлэн хамгааллыг нэвтрүүлэх нь төсөл, Дэлхий байгаль хамгаалах сан нь Дөрвөлжин суманд Нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичиг боловсруулах ажлыг санхүүжүүлж гүйцэтгэгчээр "Вектор мэл" ХХК, Ховд их сургуультай хамтран Дөрвөлжин суманд эхний шат болох хээрийн судалгааны ажлыг хийж дуусгаж багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлж саналыг тусган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг эцсийн байдлаар боловсруулж 2017 оны 12 дугаар сарын 18-н өдрийн сумын ИТХ-аар хэлэлцүүлж батлуулсан. Тухайн төлөвлөгөө болон аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд газар, байгалийн нөөц эдэлбэрийн зүй ёсны эрхийг баталгаажуулах ажлыг тусгасан.

2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө, төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар баригдсан 29 барилга байгууламж их засварын ажилд техник хяналт хийсэн ажлын тайланг гарган Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн.

Япон улсын буцалтгүй тусламжаар Тэлмэн сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга, Алдархаан сумын сургуулийн дотуур байрны засварын ажлыг тус тус ашиглалтанд хүлээлцүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаа.



ГХБХБГ-ын барилгын материалын лабораторид хийгдсэн ажлын тайлан, орон сууц нийтийн аж ахуйн чиглэлээр хийгдсэн ажлын тайлан, Барилга угсралтын ажлын төсвийг бодитой болгох зорилгоор орон нутгийн түгээмэл тархацтай орд газар, орон нутгийн барилгын материалын үнэ, сумдын барилгын материал татах тээврийн зайг маягтын дагуу тус тус гарган Барилгын хөгжлийн төвд 2017 оны 12 сарын 15 өдрийн 591 тоот албан бичгээр хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд Чигнэс бондын эх үүсвэрийн зээлд барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр хамрагдсан 5 аж ахуйн нэгж, 2 иргэний судалгааг гарган БХБЯ-нд 2017 оны 12 сарын 15 өдрийн 592 тоотоор гарган хүргүүллээ. Ирэх онд шинээр баригдах болон их засвар хийгдэх 50 гаруй барилга байгууламжийн ажлын зураг төсөв хийгдсэн судалгааг гаргалаа. Жинст багийн 36 айлын орон сууцны халаалт доголдсон талаар иргэдээс гомдол ирж шалтгааныг тодруулахаар аймгийн Засаг даргын захирамжаар холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулан ажлын хэсэг байгуулан газар дээр танилцаж холбогдох арга хэмжээг авч ажиллаа.

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР